

Агуулга

1. ОРШИЛ.....	4
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	10
4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	13
4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл ...	13
4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл ...	13
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
10. ХИМИЙН БОДИС, ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23

Зургийн жагсаалт

Зураг 1 Талбайн байрилын тойм зураг.....	6
--	---

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол.....	5
Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	15
Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
Хүснэгт 4 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
Хүснэгт 5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	22
Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
Хүснэгт 8 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	23

1. ОРШИЛ

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Баян амны болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн Ам” алтны шороон ордын 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2021 онд батлуулсан ТЭЗҮ болон 2022 онд батлуулсан БОННУ, 2025 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн боловсруулав.

“Вестернресурс” ХХК нь Баяны ам болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн амны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөлд шинээр хөрөнгө оруулалт татаж, олон улсад үнэлэгдсэн, шилдэг менежментийн багаар удирдуулан, байгаль орчинд ээлтэй уул уурхайн шинэ технологи, аргачлалыг ашиглан элсийг угаан баяжуулах технологи ашиглан үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байна. “Баян амны болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн Ам”-ын алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийг тооцон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тогтоогдсон ажлуудыг цаг тухай бүрд зардлыг төсөвлөн зайлшгүй авах дараах арга хэмжээнүүдийг дагаж ажиллана.

Нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд тавих үндсэн шаардлага, байгалийн үндсэн бүсээс хамаарах агротехникийн шаардлага, ургамлын нөхөн сэргээлтийн үе шатууд, тарих ургамлуудыг сонгох болон нөхөн сэргэсэн газрыг хүн, мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах, нөхөн сэргээж буй газрын хөрс, ургамлын хяналт шинжилгээнд тавих шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах байгалийн нөөц баялгийг чадавхтайгаа уялдуулан төлөвлөх, хамгаалах, зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээх, байгаль орчинд учруулах орчны бохирдлын хэмжээг бууруулах, урьдчилан сэргийлэх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэгт байгаль орчны талаар гаргасан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартуудыг дагаж мөрдөх нь чухал.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Хавцгайтын ам нэртэй газарт MV-017506, Хүүшийн ам нэртэй газарт MV-017495 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээ нь харгалзан 284.85 га болон 46.27 га нийт 331.12 га бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш 720 км, Баянхонгор аймгийн Галуут сумын төвөөс баруун урагш 75 км

“БАЯН АМНЫ БОЛОН ХАВЦГАЙТЫН АМНЫ ИХ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ОРД БОЛОН ХҮҮШИЙН АМ”-НЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


зайтай орших ба ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбилцлүүдэг *Хүснэгт 1*-т харуулав. Мөн төслийн байршлын зургийг *Зураг 1* -т үзүүлэв.

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол

MV-017506			MV-017495		
№	Уртгаг	Өргөрөг	№	Уртгаг	Өргөрөг
1	100° 02' 0.51"	46° 25' 31.58"	1	100° 02' 0.51"	46° 26' 11.59"
2	100° 00' 0.51"	46° 25' 31.58"	2	100° 01' 7.82"	46° 26' 11.59"
3	100° 00' 0.51"	46° 26' 2.59"	3	100° 01' 7.82"	46° 26' 12.59"
4	100° 00' 53.51"	46° 26' 2.59"	4	100° 01' 20.37"	46° 26' 26.58"
5	100° 00' 53.51"	46° 26' 11.59"	5	100° 02' 0.51"	46° 26' 26.58"
6	100° 02' 0.51"	46° 26' 11.59"			



“БАЯН АМНЫ БОЛОН ХАВЦГАЙТЫН АМНЫ ИХ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ОРД БОЛОН ХҮҮШИЙН АМ”-НЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1 Талбайн байршлын зураг

2025 онд явагдах уулын ажил, ажиллах горим

- ✓ **Ажиллах горим.** Ордын уул техникийн нөхцөл, элсний давхаргын тогтоц, хөрсний зузаан зэргийг харгалзан үзэж автотээвэр бүхий гадаад, дотоод овоолготой ашиглалтын технологиор ашиглахаар төслийн шийдлийг гаргасан. Уг ордын сунаж тогтсон байдал нь дотоод овоолго үүсгэх, нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг багасгах, хөрсний тээвэрлэлтийн зайг богино байлгах зэрэг давуу талуудыг өгч байна. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Хавцгайт шороон орд нь улирлын чанартай ажиллах бөгөөд 4 сараас 11 сар хүртэл жилд 7 сарын хугацаатай ажиллана.
- ✓ **2025 онд явагдах уулын ажил.** 2025 онд Хавцгайтын амны ордын В-8 блокоос эхлэн олборлолтыг хийнэ. Уурхайн ашиглалтын үед нийт 3.2 сая.м³ хөрс хуулж 109.64 мян.м³ элс олборлоно. Ашиглалтын чиглэл нь зүүн урдаас баруун хойшоо чиглэлтэй буюу В-8-р блокоос эхлэн С-2 блок хүртэл олборлоно. Ил уурхайгаас гарах хөрсийг дотоод болон гадаад овоолгод хураана. Хөрсний чулуулаг нь гадаад, дотоод овоолгод буух үед 20% сийрэгжихээр тооцсон.

- Гадаад овоолго: Ашиглалтын эхний үед дотоод овоолгод хураах боломжгүй 1.8 сая.м3 хөрсийг гадаад овоолгод хураана. Гадаад овоолгийн байршил нь уурхайн урд талд нам дор газар, тээвэрлэлт зай хамгийн бага байхаар тооцон төлөвлөлсөн.
- Дотоод овоолго: Ил уурхайд хоосон орон зай үүсмэгц ажлын талбай тээвэрлэлтээ тооцон дотоод овоолго үүсгэж эхлэнэ. Ашиглалтын жилд сийрэгжсэнээр 1.79сая.м3 хөрсийг гадаад овоолгод хураана.

2025 онд 49.04 га өртөж байгаагаас баяжуулах хэсэг нийт 2.97 га талбай эвдрэлд өртөнө. баяжуулах хэсэгт анх нуур үүсгэхдээ доош 5 м ухах бөгөөд түүнээс гарсан хөрсөөр хаалт далан хийх бөгөөд техникийн нөхөн сэргээлт хийхдээ далан хийсэн шороогоор эргүүлэн дарна.

Хөрсний дотоод овоолгод нийт 8,097 мян.м3 хөрс мөн ашигласан эфель, гаалийг уурхайн уланд тарааж тэгшилнэ. Авто зам 10 га, ил уурхай 26.3 га, гадаад овоолго 9.26 га, үржил шимт хөрсний овоолго 0.53 га тус тус хамарч байна.


✓ **Тэсэлгээний ажлын тооцоо:** Уурхайн ухаж ачих процессын үр ашиг, тоног төхөөрөмжийн бүтээлийг нэмэгдүүлэх үүднээс цэвдэгтэй хөрсийг болон элсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар буталж сийрэгжүүлнэ.

- Өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоогоор хөрсөнд өрөмдөх Sunward фирмийн SWD165A маркийн өрмийн машиныг ашиглах ба цооногийн диаметр 165 мм.
- Ил уурхайн тэсэлгээний ажилд устай нөхцөлд Эмульс, усгүй нөхцөлд энгийн найрлагатай АНФО тэсрэх бодис хэрэглэх ба эгнээ хоорондын богино удаашруулагч хэрэглэн тэсэлгээний ажлыг явуулна.
- Ордын тэсэлгээний ажлыг тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй компаниар гэрээгээр хийж гүйцэтгүүлнэ.

✓ **Ил уурхайд ажиллах үндсэн техник, тоног төхөөрөмж, бүтээлийн тооцоо.** Уурхайн хөрс хуулалтын ажилд CAT 390 3ш, Doosan700 1ш, CAT 385 2ш, CAT 349 2ш, элс олборлолтын ажилд Hyundai 520 4ш, CAT 330 экскаватор 1ш, хөрс тээвэрлэлтийн ажилд CAT773 50т даацтай автосамосвал 7ш, HOWO 50т даацтай автосамосвал 24ш, элс тээвэрт HOWO 25т даацтай автосамосвал 4ш тус тус ашиглана. Ул тааз цэвэрлэгээ болон туслах ажилд CAT D8 маркийн бульдозер 3ш,

CAT D6 маркийн бульдозер 1ш, скрубер тэжээлээр хангах болон туслах SEM 650 маркийн 3 м3 утгуурын багтаамжтай утгуурт ачигч 4ш тус тус ашиглана. Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийн тоо төслийн хүчин чадлаас давсан харагдаж байх боловч техникийн бэлэн байдал, эвдрэл гэмтлийг тооцож нөөц техникүүдийг төлөвлөсөн болно

Ажил	Процессууд (тоног төхөөрөмж)	
Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх	Овоолох
	Бульдозер	Бульдозер
Цэвдэггүй хөрс хуулалт	Ухаж түрэх	Овоолох
	Бульдозер	Бульдозер
Цэвдэгтэй хөрс хуулалт	Өрөмдөж	Тэслэх
	Ухаж ачих	Овоолго
	Экскаватор, автосамосвал	Автосамосвал, бульдозер
Элс олборлолт	Өрөмдөж	Тэслэх
	Экскаваци	Тээвэрлэлт
	Экскаватор	Автосамосвал
		Угаах төхөөрөмж



Зураг 2 Ил уурхайн процессын схем

- ✓ Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй. Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд

зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг.

- ✓ **Шатах тослох материалын агуулах.** Хавцгайтын амны алтны шороон орд нь дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн бүсэд байрших тул уурхайн түлшний эргэлтийн нөөцлөлтийг 15 хоногоор тооцсон. Шатах тослох материалыг галын аюулгүй байдал хангасан, тусгай контейнерт засварын хэсгийн хашаанд хадгалдаг.
- ✓ **Сэлбэг материалын агуулах.** Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад сэлбэг материалын агуулах нь уурхайн хотхонд буюу засвар механикийн хэсгийн хажууд байна.
- ✓ **Үржил шимт хөрс хуулалт.** Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй Төсөл хэрэгжих талбай нь физик газарзүйн мужлалын ангиллаар (Даш, 1999,2015) Хангай Хэнтийн уулархаг мужид хамаарна. Хангайн-Хэнтий уулархаг их муж нь 185,314.3 км², талбайн хэмжээгээр нутаг дэвсгэрийн 11.8%, Орхон-Туул голын сав газрын бэсрэг уулсын муж 102,216.1 км², талбайн хэмжээгээр 6.5 хувийг тус тус эзэлнэ. Энэхүү бүс нутаг нь далайн төвшнөөс дээш 2100-2700 м-ийн хэлбэлзэлтэй өндөрлөг бүхий нурууны дундах налуу хотос газрыг хамарна. Жаргалантын нурууны төв хэсгийн ноён оргил болох Мөнгөө хайрхан (2693.1 м), Балгант хайрхан (2726.6 м) уулуудын дунд байрлах Хайрхан давааны өврөөс эх авсан Хоолой худгийн хөндийг эмжээрлэн байрлана. Хоолой худгийн хөндий адаг хэсэгтээ нэлээд өргөсөн улмаар Бурхант хөндийн зүүн хойноос нийлж, Хавцгайтын хөндий болон Жаргалантын нурууг зүүн хойшоо нэвт туулж “Олон нуурын” гэх уулс хоорондын том хөндийтэй нийлнэ.

Судалгааны талбайн дэвсгэр нутаг нь хүрэн чулууны уулын өмнөд бэл хормойн хэсгийг хамарсан баруун урагшаа налуу байрлалтай, хуурай сайр жалгуудаар бага зэрэг хэрчигдсэн мөлгөр гадаргуутай хуримтлалын гүвээ гүдэнгүүд зонхилсон байдаг.

Усан сүлжээ: Төслийн талбайн усан сүлжээ нь Монгол орны усны сав газрын ангиллаар Орог нуур-Түй голын сав газарт хамаарагдаж байна. Энэ ай савд Хангайн нурууны гол усан хагалбараас эх авсан Түйн, Таацын голууд орох ба эдгээр голуудын голдирол нь хэвийн байдалдаа 25-80 м, үерлэсэн үедээ 150-200 м болж хэлбэлзэх ба гүн нь 0.5-1.5 м, харгиа боргиотой хэсэгт 0.2-0.3 м, хадан хавцлын хоорондын цүнхлүүдэд 2.5-3.0 м хүрдэг.

Гүний худгаас хүн малын ундны болон ахуйн хэрэглээнд, мөн техникийн зориулалтаар усыг ашиглаж байна. Жилийн хур тунадасны хэмжээ дунджаар 280 мм буюу зуны 6-7 дугаар сард ихэвчлэн бороо орно.

Ан амьтад: Төслийн талбай байрлах тухайн бүс нутаг нь Амьтны газарзүйн мужлалаар Говийн дэд муж, Говь-Алтайн уулын тойрог, Алтайн өмнөх Говийн тойргийн заагт хамаарна. Тус тойрогт жижиг хөхтнөөс говийн алга даага, дагуур огдой, шар чичүүл, дагуур үхэр огдой, хөх шишнүүхэй, сохор огдоно, урт сүүлт зусаг, дэлдэн зараа, туулай зэрэг байдаг бол мах идэшт амьтдаас цагаан үен, хотны үен, хярс, үнэг чоно амьтдын амьдрах орчин болдог онцлогтой.

Ургамал зүй: Хүүшийн ам болон Хавцгайтын ам төслийн талбайд жижиг үетэн-хялганат сийрэг ургамалтай уулын хээрийн бүлгэмдэл зонхилсон. Төслийн талбай орчимд олон наст өвслөг ургамлууд зонхилж ургасан ба эдгээрээс өдлөг хялгана - *Stipa glaeosa*, агь - *Artemisia frigida*, ахар навчит хунчир - *Astragalus brevifolius* зонхилон ургаж байна. Нэг болон цөөн наст ургамлаас шоргор лууль - *Chenopodium acuminatum*, баг хуш хамхаг – *Halogeton glamoireus* тус тус зонхилон ургаж байна. байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн судалгаагаар нийт төслийн талбайд 10 овгийн 16 төрлийн 21 зүйл ургамал бүртгэгдсэн.

Уур амьсгал: Төслийн талбай нь эрс тэс уур амьсгалтай бүс нутагт хамаарна. Хамгийн хүйтэн үе I сард -400С, хамгийн халуун сар нь VII сард +250С байна. Жаргалантын нуруу нь Хангайн нурууны өмнөд салбар уулсад хамаарах, харьцангуй өндөрлөг газар учир тал хээр, говийн нутгаас илүү хур тунадас унадаг. Ихэнх хур тунадас зуны улиралд VI, VII сард унадаг. Жилийн нийт хур тунадасны хэмжээ дунджаар 280 мм байна.**Хөрс:** Хээр талын хүрэн бор өнгийн хөрс зонхилох бөгөөд хөрс нь 10-40 см зузаантай, сул нягтарсан шавранцар, элсэнцэр, хайрганцар, дайрга, сайрга бүхий хурдсаас бүрдэнэ.

Цэвдэгшил ба газар хөдлөлт: Тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол орны 1:1500 000 масштабтай геокриологийн зурагт үзүүлснээр олон жилийн цэвдгийн ховор алаг цоог тархалттай бүслүүрт оршино. Энэ бүслүүрт олон жилийн цэвдгийн зузаан 6–50 м, зарим хэсэгт үүнээс ч зузаан, олон жилийн цэвдгийн температур нь 0 – (-1⁰С) орчим байна. Хөрс нь 10-р сарын 15-ны үеэс өнгөнөөсөө хөлдөж улмаар 1-2 сард хамгийн гүндээ хүрнэ. Мөн 4-р сарын эхнээс 6-р сарын дунд үе хүртэл өнгөнөөсөө гэсэж цэвдгийн үед тулна. Цэвдэгшил нь газрын гадаргаас доош 6-8 м-ээс эхэлж гүн болох тусмаа усжилт их болж цэвдгийн үе үргэлжилнэ. Ордын тусгай зөвшөөрлийн талбай нь газар хөдлөлтийн 2-4 баллын бүсэд байрлана.

Газрын гадарга: Галуут сумын нутаг дэвсгэр нь Их богд уулын тусгай хамгаалалттай газарт хамаарах Хангайн гол ноён нурууны төв хэсгийн уулсын зүүнээс Доной, Гурван анаг, Өхүгийн эх, Хуримт нуруудыг дамжин Ёлын баруун нурууг хүртэл 157224 га газар нутаг хамаардаг. Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс 3539 м-ийн өндөрт өргөгдсөн Гурван анагийн нуруу, хамгийн нам дор газар нь 2040 м өндөрт өргөгдсөн Олгой нуурын хөвөө юм. Сумын нутаг дэвсгэр нь монгол орны физик газар зүйн мужлалаар хангайн уулархаг их мужийн дэд муж болох далайн түвшинээс дээш 2000-3000 м-ийн өндөрт орших хангайн нурууны салбар уулсын хэсэгт хамаардаг.

Газрын нөөц: Сум нь 504,7 мянган га эдэлбэр нутагтай. Үүнээс 339,5 мянган га хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 2,7 мянган га ойн сан бүхий газар, 883 га усны сан бүхий газар, 4,1 мянган га газар нь төв суурины эдэлбэр газар байна.

Түүхийн дурсгалт газрууд: Сумын нутагт Галуутын хавцал, Баяннуур, Дуут нуур, Ёл, Өргөөтийн тогоо, Саалингийн хавцал, Донойн олон нуур, Олгой нуур, Ногоон нуур, Ширээ нуур, Мөнх цасны хоолой, Ёлын цэцгийн хонхор, Дэл хайрхан, Хуримт нуур, Бөөрөг нуур, Өхүгийн Зостын ам зэрэг байгалийн үзэсгэлэнт болон өвөрмөц тогтоц бүхий газартай. Мандлын хийдийн сүм дуганууд, Бурхант хясаа, Бурхантай хад, Эвдэрхий хийдийн туурь, Буянт голын хүн чулуу, Өргөөтийн овооны буган чулуу, Харганы агуй, Түрэгийн үеийн хөшөө чулуу, Бичигт хад, Эрдэнэ тээлийн хүрээний туурь, Дандарын овоо, Бөх Цагааны чулуу, Дөрвөлжин шавар, Олон овооны таг, Дүнгэнэдэг дов, Өвөр шавартын зах зэрэг түүх соёлын дурсгалт газрууд олонтой.

Зам харилцаа: Тус талбай нь зам харилцааны хувьд харьцангуй сайн хөгжсөн гэж үзэж болох бөгөөд Улаанбаатар хотоос Баянхонгор хүртэл хатуу хучилттай замаар зорчино. Цааш талбай хүртэл мөн талбайн хэмжээнд авто тээврээр зорчиход ямар нэгэн бартаа саадгүй замын сүлжээ сайн хөгжсөн байдаг. Хээрийн замыг автомашинаар жилийн бүх улиралд ашиглах боломжтой.

Уурхайн дотоод зам нь шилжилт хөдөлгөөн их хийгддэг тул шилжилттэй түр замаар хөрс болон элс тээвэрлэхээр тооцоолсон ба уурхайгаас боловсруулах үйлдвэр болон засвар механикийн цех хүрэх зам нь байнга ашиглагдах тул сайжруулсан байнгын зам тавина. Замын байгууламж нь нийт 5 км урттай байна. Уурхайн дотоод замд хөрс болон элс тээврийн автомашины хөдөлгөөний дундаж хурд нь автомашины овор хэмжээ, замын ачаалал, хөдөлгөөний эрчим, аюулгүй байдал зэргээс хамаарч 25 км/цаг байх ба хөдөлгөөний 2 зурвастай, 20 метрийн өргөнтэй байхаар тооцоолсон.

Эрчим хүч: Үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд цахилгааны хэрэгцээгээ дизель цахилгаан станцаар хангадаг. Цахилгаан дамжуулах шугам сүлжээгүй, хамгийн ойрын цахилгааны шугам нь Бөмбөгөр сумын нутагт (50 км) байдаг.

4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд уулын ажлын хөрс хуулалт, элс олборлох үед тээвэрлэлтээс хөрсөн бүрхэвч элэгдэн, сул шороо, тоосжилт үүсэх, уурхайд ажиллах машин техникээс ялгарах утаа, хорт хийнүүд агаар орчныг бохирдуулах гол сөрөг нөлөөлөл юм.

4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Баян амны болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн амны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжих талбайн ойролцоо буюу Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт гол мөрөн, нуур цөөрөм зэрэг гадаргын ус байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагаанд технологи, унд ахуй, зам талбай усалгаа, биологийн нөхөн сэргээлтэд ус ашиглахаар байна. Усыг тогтсон норм хэмжээнээс хэтрүүлэн ашиглавал усны нөөцөд нөлөөлж болзошгүй юм

4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

Баянхонгор аймгийн Галуут сумын Вестерн ресурс ХХК-ийн төслийн талбай нь ургамал газарзүйн тойргоор Хангайн уулын ойт хээрийн тойрог, олон нуурын хөндийн цөлөрхөг хээрийн тойрогын заагт байрлаж байна. Хөрс хуулагдсанаар эдгээр талбайн ургамлан нөмрөг шууд устгах, Машин техникийн хөл хөдөлгөөн болон олон салаа зам гарснаар ургамлан нөмрөг талхлагдаж доройтож болзошгүй.

4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй. Уурхайн эвдэрсэн

газрыг нөхөн сэргэсний дараа буй шаардлагатай ургамалуудыг тариалалт хийсний дараа мал, амьтан орж сүйтгэж, үерийн усаар угаагдах зэрэг учирч болох доройтол болон сөрөг нөлөөллүүдээс сэргийлж хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллана.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Вестернресурс” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй. Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов. “Баян амны болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн Ам”-ын алтны шороон ордын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийг тооцон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тогтоогдсон ажлуудыг цаг тухай бүрд зардлыг төсөвлөн зайлшгүй авах дараах арга хэмжээнүүдийг дагаж ажиллана.

Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм;	Мот/цаг, засвар үйлчилгээ	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
		Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол усалж байна.	Дотоод тээврийн зам	Нэгж усалгаа	Дотоод үйл ажиллагааны зардалд		
		Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх	Ажилчид		500 000		
		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	Уурхайн зам	-	500 000		
	Нийт	1 000 000					
	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	-		Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана.	1 000 000				
		Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах	Дотоод үйл ажиллагааны зардалд				
	Нийт	1 000 000					

“БАЯН АМНЫ БОЛОН ХАВЦГАЙТЫН АМНЫ ИХ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ОРД БОЛОН ХҮҮШИЙН АМ”-НЫ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх		-	300 000	Төслийн хугацаанд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
	Уурхайн хуулсан Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах	Шимт хөрсний овоолго			2025 онд	
	Хадгалсан шимт, шимэрхэг хөрсийг нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглах				Төслийн хугацаанд	
	Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Засвар үйлчилгээний талбай			Төслийн хугацаанд	
	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулах, аюултай хог хаягдлыг зөвшөөрөгдсөн газарт нийлүүлэх	Засварын талбай, авто зогсоол, карерь	-	300 000	Төслийн хугацаанд	
	Ахуйн бохир усыг танк хуримтлуулан цэвэрлэх байгууламж руу нийлүүлэх	Тээвэрлэлт		400 000	Төслийн хугацаанд	
Нийт	1 000 000					
Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
	Мал амьтан унахаас сэргийлэн хайс, хашлага хийх	Уурхайн хотхонд	-	1 000 000	Төслийн хугацаанд	
Нийт	1 000 000					
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 4 000 000					

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд дотоод овоолгоор **2.4 га** талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил, **1.5 га** талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Техник болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай эвдрэл орохоос урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллана.

✓ Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, буцыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

✓ Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налуугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

✓ Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	га	2.4	-	-	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага “MNS 5918:2008”
2.	Биологийн нөхөн сэргээлт	га	1.5	-	4 500 000	
3.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	ш	1000	1000	3 000 000	
4.	Нийт				7 500 000	

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орон нутгийн удирдлага, иргэдийн хүсэлт, мэргэжлийн судлаач нарын зөвлөгөөн, хэлэлцүүлэг дээр үндэслэн нөхөн сэргээлт хийх болон биологийн олон янз байдлын нарийвчилсан судалгааг явуулах зэрэг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй. “Вестернресурс” ХХК нь 2025 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас тогтоож өгсөн **1.0 га** газарт өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөөд байгаа юм.

Хүснэгт 4 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1	Сумын нутаг дэвсгэрт нөлөөлөлд өртөж эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ	Нөхөн сэргээлт	га	1.0	-	7 500 000
	Нийт	7 500 000				

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Вестерн ресурс” ХХК -ны Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Баян амны болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн амны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Вестернресурс” ХХК-ний “Баян амны болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн Ам”-ын алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Галуут сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад мэдэгдэнэ.

10. ХИМИЙН БОДИС, ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ил уурхайн тэсэлгээний ажлыг хоногт нэг удаа хийх ба уулын цулыг энгийн тэсрэх бодис ANFO-оор тэслэх ба устай цооногт эмульсийн тэсрэх бодис хэрэглэнэ. Баян амны болон Хавцгайтын амны их гүний дарагдмал орд болон Хүүшийн Амны алтны шороон ордын тэсэлгээний ажлыг тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй “Мастер Майнинг Сервис” ХХК компаниар гэрээгээр хийж гүйцэтгүүлнэ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
1	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	ҮА зардалд	Төслийн хугацаанд
2	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох		
3	Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах		
4	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах		
5	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх	1 000 000	
Нийт		1 000 000	

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Ахуйн болон бусад хатуу хог хаягдлыг ангилсны дараагаар дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаана. Ашигласан тосыг битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна.

Хаягдал зайлуулах нүх/савыг сард нэгээс доошгүй удаа ариутгах ба бие засах газар, шүршүүрийг өдөр бүр цэвэрлэж, ариутгана. Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар бохир усны нүх, сав, бие засах газрыг ариутган булж тэгшлэн нөхөн сэргээнэ.

Хүснэгт 5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх, хатуу хог хаягдлыг доторжуулах, зарим хаягдлыг нэгдсэн журмаар хог хаягдлын цэгт хаях.	1 000 000	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
		Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал	500 000		
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна. Ахуйн хатуу хаягдал ялгаж хаях сав 500-1000 кг хог хаях багтаамжтай 4-6 тасалгаатай сав байна.	2 000 000	Үйл ажиллагааны турш	
		Хог хаягдал, ялган ангилалт, түүний үр ашгийн талаар сургалт, мэдлэг олгох	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах			
2.	Үйлдвэрийн	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын сав байршуулах /Тэсэлгээний агуулах, засварын хэсэг /	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Уул уурхайн тоног төхөөрөмжөөс гарах нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл хаягдлыг хяагдал зайлуулах газарт шилжүүлэн хаяна.			
	Нийт зардал 3 500 000				

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах төлөвлөгөө авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2025 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаар төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Хүснэгт 6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаар	Засварын талбай ажилчдын хотхон, уурхайн карьер, уурхайн зам	6, 9-р сард	4 цэгт 2 удаа	40000	800 000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ	Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	Ахуйн бохир усны хаягдал орчимд, шимт хөрсний овоолго, засварын талбай	6, 9-р сард	3 цэгт 2 удаа	70000	4 200 000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур, ахуйн хаягдал ус	6, 9-р сард	4 цэгт 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50000 төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 100000 төг *УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ Мөн элс угаан баяжуулах нуурын усанд хүнд металлын шинжилгээ өгнө.	2 600 000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995,
	Нийт					7 600 000		

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь 2025 он	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод үйл ажиллагааны зардал	Төслийн хугацаанд	Уурхайн дарга
2.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх		7 р сард	Уурхайн дарга
3.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх		11-р сар	“Вестернресурс” ХХК-ийн удирдлагууд
4.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих		Сар бүр	

Хүснэгт 8 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1,000.0
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал	1,000.0
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1,000.0
4	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	900.0
5	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	3,500.0
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	1,000.0
7	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	12,500.0
8	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардал	7,500.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	7,600.0
	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	36,000.0

2025 оны 04-р сарын 14-ны өдөр нэмэлтээр 6,320,000₮ тушааж нийт 12,640,000₮ барьцаа төлбөрийг тушаасан ба 2025 оны 05-р сарын 08-ны өдөр 5,360,000 тушааж нийт 18,000,000 барьцаа төлбөрийг тушааж 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүнг 36,000,000 болгож нэмэгдүүлэв.